



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/61/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: tsaranchimeg@audit.gov.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Төлбөрийн акт	17
4.3 Албан шаардлага.....	17
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/151
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА А.МӨНХТУУЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

19032/75
D 2022/2021

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	109,353,999.45	106,710,903.36
33	АВЛАГА	8,210,447.45	1,725,001.36
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	40,355.36
335	Бусад авлага	8,210,447.45	1,684,646.00
3351	Байгууллагаас авах авлага	5,121,387.45	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,089,060.00	1,684,646.00
35	БАРАА МАТЕРИАЛ	101,143,552.00	104,985,902.00
354	Хангамжийн материал	101,143,552.00	101,228,902.00
35410	Бичиг хэргийн материал	425,530.00	40,900.00
35420	Аж ахуйн материал	81,277,211.00	81,770,211.00
35470	Бусад хангамжийн материал	19,440,811.00	23,174,791.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,477,142,495.72	1,383,194,211.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,477,142,495.72	1,383,194,211.99
392	Биет хөрөнгө	1,343,161,287.70	1,249,639,878.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	807,880,657.00	807,880,657.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(307,087,464.22)	(409,572,954.46)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	225,770,667.20	225,770,667.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	(114,864,000.56)	(146,627,334.26)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	279,870,559.50	280,310,559.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(155,610,627.23)	(190,307,964.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,085,587.00	29,085,587.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,923,261.66)	(13,639,472.63)
39209	Зам, гүүрийн байгууламж	399,123,410.00	409,123,410.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(254,899,415.26)	(286,139,835.20)
39214	Бусад үндсэн хөрөнгө	580,485,063.55	744,580,036.55
39215	Хуримтлагдсан элэгдэл	(140,669,887.62)	(200,823,477.03)
393	Биет бус хөрөнгө	133,981,208.02	133,554,333.24
39301	Програм хангамж	2,040,000.00	2,040,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(944,791.98)	(1,371,666.76)
39303	Бусад биет бус хөрөнгө	132,886,000.00	132,886,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,586,496,495.17	1,489,905,115.35
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,125,139.60	1,055,146.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,125,139.60	1,055,146.00
413	Өглөг	1,125,139.60	1,055,146.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	968,350.00	-
4136	Бусад өглөг	156,789.60	1,055,146.00
41361	Байгууллагад төлөх өглөг	150,000.00	1,039,146.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	6,789.60	16,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,585,371,355.57	1,488,849,969.35
51	Засгийн газрын хувь оролцоо	1,585,371,355.57	1,488,849,969.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын	916,474,832.44	916,474,832.44
51101	Өмч: - төрийн	916,474,832.44	916,474,832.44
512	Хуримтлагдсан үр дүн	478,656,791.07	382,135,404.85
51210	Өмнөх үеийн үр дүн	478,656,791.07	478,055,791.07
51220	Тайлант үеийн үр дүн	-	(95,920,386.22)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	190,239,732.06	190,239,732.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,586,496,495.17	1,489,905,115.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	633,301,642.44	707,982,693.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63,547,610.59	195,282,635.00
120	Нийтлэг татварын бус орлого	63,547,610.59	195,282,635.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,666,349.59	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,666,349.59	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	569,754,031.85	512,700,058.04
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,252,353.85	96,370,158.04
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан	4,363,355.00	14,859,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	14,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,862,628.85	50,006,469.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,026,370.00	17,004,189.04
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	525,501,678.00	416,329,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	525,501,678.00	416,329,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	633,475,579.83	803,919,174.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	633,475,579.83	803,919,174.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	606,398,472.70	781,139,364.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250,206,620.58	259,384,726.12
210101	Үндсэн цалин	167,706,338.06	173,333,617.59
210102	Нэмэгдэл	43,635,161.52	43,865,245.54
210105	Гэрээт ажлын хөлс	38,865,121.00	42,185,862.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,511,449.03	33,454,799.44
210201	Тэтгэврийн даатгал	21,309,398.13	23,254,572.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,768,158.48	2,580,878.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,001,653.16	2,064,702.90
210204	Ажилгүйдлийн даатгал	493,117.06	493,591.86
210205	Эрүүл мэндийн даатгал	4,939,122.20	5,061,053.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,310,599.06	46,021,159.00
210301	Гэрэл, цахилгаан	12,323,878.06	11,763,847.00
210302	Түлш, халаалт	32,574,221.00	32,817,312.00
210303	Цэвэр, бохир ус	412,500.00	1,440,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,228,699.00	23,441,505.80
210401	Бичиг хэрэг	3,136,570.00	2,737,130.00
210402	Тээвэр, шатахуун	10,651,129.00	12,782,745.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,441,000.00	3,893,780.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	-	4,027,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	2,982,200.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	2,982,200.00
2107	Томилот, зочны зардал	2,719,000.00	1,748,000.00
210702	Дотоод албан томилот	2,719,000.00	1,748,000.00

**Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	14,148,875.00	2,354,805.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	13,003,575.00	1,209,505.63
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	340,000.00	340,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	311,100.00	311,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	329,200.00	329,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	165,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	246,273,230.03	411,752,168.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,878,790.85	143,164,911.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	193,394,439.18	268,483,256.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,077,107.13	22,779,809.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,448,500.00	6,409,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,448,500.00	6,409,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,628,607.13	16,369,909.64
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,628,607.13	16,369,909.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(173,937.39)	(95,936,481.22)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	16,095.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	16,095.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	23,274,190.68	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,874,190.68	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	17,400,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(23,274,190.68)	16,095.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(23,448,128.07)	(95,920,386.22)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	916,474,832.44	206,127,430.80	384,656,853.40	1,507,259,116.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,978,909.83	1,978,909.83
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	916,474,832.44	206,127,430.80	386,635,763.23	1,509,238,026.47
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-23,448,128.07	-23,448,128.07
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	916,474,832.44	190,239,732.06	478,656,791.07	1,585,371,355.57
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	916,474,832.44	190,239,732.06	478,656,791.07	1,585,371,355.57
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-601,000.00	-601,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	916,474,832.44	190,239,732.06	478,055,791.07	1,584,770,355.57
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-95,920,386.22	-95,920,386.22
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	916,474,832.44	190,239,732.06	382,135,404.85	1,488,849,969.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	562,757,031.85	519,579,557.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,000.00	78,683.51
120	Нийтлэг татварын бус орлого	3,000.00	78,683.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,000.00	78,683.51
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000.00	78,683.51
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	562,754,031.85	519,500,874.04
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,252,353.85	103,170,974.04
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан	4,363,355.00	14,859,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	-	14,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан	17,862,628.85	50,006,469.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	15,026,370.00	23,805,005.04
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	525,501,678.00	416,329,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	525,501,678.00	416,329,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	438,943,956.85	519,139,557.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	438,943,956.85	519,139,557.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	410,726,043.72	496,359,747.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250,206,620.58	259,496,973.14
210101	Үндсэн цалин	167,706,338.06	173,445,864.61
210102	Нэмэгдэл	43,635,161.52	43,865,245.54
210105	Гэрээт ажлын хөлс	38,865,121.00	42,185,862.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,511,451.29	33,454,799.44
210201	Тэтгэврийн даатгал	21,309,400.39	23,254,572.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,768,158.48	2,580,878.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,001,653.16	2,064,702.90
210204	Ажилгүйдлийн даатгал	493,117.06	493,591.86
210205	Эрүүл мэндийн даатгал	4,939,122.20	5,061,053.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,697,607.00	46,021,159.00
210301	Гэрэл, цахилгаан	10,710,886.00	11,763,847.00
210302	Түлш, халаалт	32,574,221.00	32,817,312.00
210303	Цэвэр, бохир ус	412,500.00	1,440,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,442,329.00	25,025,225.80
210401	Бичиг хэрэг	3,300,700.00	2,352,500.00
210402	Тээвэр, шатахуун	10,651,129.00	12,782,745.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,490,500.00	3,893,780.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	-	5,996,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	2,981,200.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	2,981,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,719,000.00	1,748,000.00
210702	Дотоод албан томилолт	2,719,000.00	1,748,000.00

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	16,648,875.00	2,354,805.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	15,503,575.00	1,209,505.63
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	340,000.00	340,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	311,100.00	311,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	329,200.00	329,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	165,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,500,160.85	125,277,584.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,500,160.85	125,173,584.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,217,913.13	22,779,809.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,448,500.00	6,409,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,448,500.00	6,409,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,769,413.13	16,369,909.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,769,413.13	16,369,909.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	123,813,075.00	440,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	123,813,075.00	440,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	123,813,075.00	440,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	123,813,075.00	440,000.00
222001	Тоног төхөөрөмж	1,000,000.00	-
223001	Бусад хөрөнгө	850,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	121,963,075.00	440,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	(123,813,075.00)	(440,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	416,329,900.00	412,314,611.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	416,329,900.00	412,314,611.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	409,920,000.00	405,904,711.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,284,200.00	259,496,973.14
210101	Үндсэн цалин	173,682,100.00	173,445,864.61
210102	Нэмэгдэл	43,934,800.00	43,865,245.54
210105	Гэрээт ажлын хөлс	42,667,300.00	42,185,862.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,138,200.00	33,454,799.44
210201	Тэтгэврийн даатгал	24,727,000.00	23,254,572.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,602,800.00	2,580,878.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,082,200.00	2,064,702.90
210204	Ажилгүйдлийн даатгал	520,500.00	493,591.86
210205	Эрүүл мэндийн даатгал	5,205,700.00	5,061,053.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,158,500.00	46,021,159.00
210301	Гэрэл, цахилгаан	12,673,200.00	11,763,847.00
210302	Түлш, халаалт	33,045,300.00	32,817,312.00
210303	Цэвэр, бохир ус	1,440,000.00	1,440,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,047,800.00	19,837,780.00
210401	Бичиг хэрэг	2,352,500.00	2,352,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,595,300.00	7,595,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,100,000.00	3,893,780.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгах	6,000,000.00	5,996,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,945,300.00	1,748,000.00
210702	Дотоод албан томилолт	1,945,300.00	1,748,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	1,145,300.00	1,145,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	340,000.00	340,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	311,100.00	311,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	329,200.00	329,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	165,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,700,700.00	42,700,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,700,700.00	42,700,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,409,900.00	6,409,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,409,900.00	6,409,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэ	6,409,900.00	6,409,900.00
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	416,329,900.00	412,314,611.58
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	416,329,900.00	412,235,928.07
132001	Орон нутгийн төсвөөс	416,329,900.00	412,235,928.07
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	27
620001	Удирдах ажилтан	6	6
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8
620003	Үйлчлэх ажилтан	6	6
620004	Гэрээт ажилтан	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,111,547.85	103,170,974.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,111,547.85	103,170,974.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,111,547.85	90,895,036.33
2104	Хангамж, бараа материалын зардал	-	5,187,445.80
210402	Тээвэр, шатахуун	-	5,187,445.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,481,200.00
210604	Урсгал засвар	-	1,481,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	7,149,425.00	1,209,505.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	7,149,425.00	1,209,505.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,962,122.85	83,016,884.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,962,122.85	82,912,884.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,000.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	-	12,275,937.71
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	36,111,547.85	103,170,974.04
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,111,547.85	103,170,974.04
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс	4,363,355.00	14,859,500.00
131103	ЗГНХ ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй	-	14,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан	17,862,628.85	50,006,469.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны	13,885,564.00	23,805,005.04
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн № 03/35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газар нь сумын эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого зохицуулалтаар хангах, нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад чиглэсэн оновчтой бодлого зохицуулалтаар хангах, захиргааны удирдлага, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, байгууллагын хүний нөөцийг сайжруулах, хувь хүний чадавх, харилцаа хандлагыг өөрчлөхөд анхаарч, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд дэмжлэгийг үзүүлэх чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн байгууллага юм.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/01 тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын багийг, дотоод хяналт зохион байгуулах журмын хамтаар баталсан байна. Тайлант онд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас өвсний тооцоог шалгасан байна. 12 дугаар сард Аймгийн Засаг даргын үзлэг хяналт шалгалт хийсэн байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 633,301.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 9,499.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 7,124.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 10,619.7 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 1,120.2 мянган төгрөгөөр өссөн байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 7,964.8 мянган төгрөгөөр тогтоогдсон байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Аймгийн ТЕЗ-ийн байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруз сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 416,329.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 96,370.2 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 195,282.6 мянган төгрөг, нийт 707,982.7 мянган төгрөг өмнөх оноос 74,681.1 мянган төгрөгөөр буюу 111,8 хувиар өссөн байна.

Зардал:

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газар 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 803,919.2 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 519,139.6 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 412,314.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140155001 тоот дансанд 2021 онд 416,329.9 мянган төгрөгийн орлого, 416,329.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140155408 тоот дансанд 103,171.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, 103,171.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.0	2.0	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	8,210.4	1,725.0	(6,485.4)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	101,143.6	104,985.9	3,842.4
Үндсэн хөрөнгө	1,477,142.5	1,383,194.2	(93,948.3)
Нийт хөрөнгө	1,586,496.5	1,489,905.1	(96,591.4)
Өр төлбөр	1,125.1	1,055.1	(70.0)
Засгийн газрын оролцоо	1,585,371.4	1,488,850.0	(96,521.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,586,496.5	1,489,905.1	(96,591.4)

Авлагын дансны үлдэгдэл 8,210.4 мянган төгрөг байсан ба тайлант хугацаанд 15,432.7 мянган төгрөгөөр нэмэгдэж 21,918.2 мянган төгрөгөөр авлага буурч 1,725.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнасан байна. Энэ нь 2021 онд СХАА-ны хяналт шалгалтаар үүссэн актын төлбөрийн авлага 1,039.2 мянган төгрөг, баг хөгжүүлэх сангийн авлага 645.5 мянган төгрөг, ажилчдаас авах авлага 40.3 мянган төгрөг байна.

Бараа материалын үлдэгдэл 101,143.6 мянган төгрөг байсан ба тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 82,758.2 мянган төгрөгийн бичиг хэрэг, шатахуун, сэлбэг хэрэгсэл, аж ахуйн болон бусад хангамжийн материал худалдан авсан, үнэ төлбөргүй орлогоор хандиваар 21,187.7 мянган төгрөгийн материал нийт 103,945.9 мянган төгрөгийн бараа материалын орлого бүртгэгдэж, 100,103.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж 104,985.9 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлан гарсан байна..

Тайлант хугацаанд шинээр үндсэн хөрөнгийн орлогод аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 71,060.3 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй халаалт, цэвэр усны шугам, 10,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдааны гудамжны халаалтын шугам, 7,500.0 мянган төгрөгийн цахим худгийн төхөөрөмж, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хүүхдийн тоглоомын талбай 20,000.0 мянган төгрөг, зам засвар 10,000.0 мянган төгрөг, сумын төвийн гэрэлтүүлэг шинээр тавихад 45,151.0 мянган төгрөг, гэрэлтүүлгийн засвар 10,383.6 мянган төгрөгийг сайжруулалтаар нийт 174,094.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлогоор бүртгэж /120017/ авсан байна. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 440.0 мянган төгрөгийн цаг бүртгэлийн төхөөрөмжийг тоног төхөөрөмжийн дансанд бүртгэсэн. Үндсэн хөрөнгийн данс 1,383,194.2 мянган төгрөг болж 93,948.3 мянган төгрөгөөр буурсан нь дээрх хөрөнгийг орлого авч 268,191.1 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийг тооцож бүртгэснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,488,850.0 мянган төгрөг болж 96,521.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 445,658.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 416,329.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 29,328.7 мянган төгрөгөөр бууруулж орон нутгийн төсвөөс 416,329.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь тогтмол зардал 11,413.5 мянган төгрөг, цалин, шимтгэлийн зардал 6,393.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 15,379.0 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардал 12,500.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 416,329.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 416,329.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 416,329.9 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 412,314.6 мянган төгрөгийг зарцуулж, 4,015.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 412,314.6 мянган төгрөг буюу 99,0 хувь зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн Аудитын код ТӨА-2022/61/-НА-СТА-ТШЗ

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газар нь нийт 103,171.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт бүрдүүлсэн байна.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 5,187.4 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1,481.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,209.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 83,016.9 мянган төгрөг нийт 90,895.1 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 12,275.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны батлагдсан зардлаас Ковид-19 цар тахлын үед шаардлагатай шатахууны зардал, оношлуур, материалын зардал болон бусад зардалд нийт 4,442.0 мянган төгрөгийг мөн шүлхий гарсантай холбогдуулан 3,452.5 мянган төгрөгийн шатахуун болон автомакс, халдваргүйтгэлийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шатахууны дэмжлэг 4,500.0 мянган төгрөг, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүгийн дэмжлэг 10,000.0 мянган төгрөг, Ковид-19 цар тахалтай холбоотой иргэн, ААН байгууллагаас өгсөн мөнгөн хандив 14,859.5 мянган төгрөг, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд сумын шилжих үлдэгдлээс хуваарилсан 15,654.3 мянган төгрөг нийт 45,013.8 мянган төгрөгийг Ковид-19 цар тахлын үед тусгаарлах байрны материалын зардал, дархлаа дэмжих витаминжуулалтын багц авах зардалд, түргэвчилсэн оношлуурын үнэнд, шатахууны зардалд, халдвар хамгаалалын хэрэгсэл, ариутгалын материалын үнэнд нийт 28,553.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. мөн шүлхий гарсантай холбогдуулан нэмэлт санхүүжилтийн данснаас 2,995.6 мянган төгрөгийн шатахууны зардал гарсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд нийт 174,535.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын дараах ажлыг бүртгэж тайлагнасан байна. Үүнд: аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 71,060.3 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 178 м халаалт, цэвэр усны шугам, 2020 оны аймгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн 10,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдааны гудамжны халаалтын шугам, 7,500.0 мянган төгрөгийн цахим худгийн төхөөрөмж, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хүүхдийн тоглоомын талбай 20,000.0 мянган төгрөг, Зам засвар 10,000.0 мянган төгрөг, сумын төвийн гэрэлтүүлэг шинээр тавих 45,151.0 мянган төгрөг, гэрэлтүүлгийн засвар 10,383.6 мянган төгрөгийг сайжруулалтаар нийт 174,094.9 төгрөгийн үнэ төлбөргүй орлогоор, төсвийн хөрөнгөөр 440.0 мянган төгрөгийн цаг бүртгэлийн төхөөрөмжийг тоног төхөөрөмжийн дансанд бүртгэсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг бүрэн байршуулсан эсэхийг шалгахад мэдээллийг бүрэн байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газар нь нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан 103,171.0 мянган төгрөгийг бусад хууль тогтоомжийн хүрээнд зарцуулан тайлагнасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээллийг бүрэн оруулах, худалдан авалт бүрийн ө баримт төлбөрийн баримтыг бүрэн баримтжуулах зөвлөмжийг 75,0% хэрэгжүүлэн ажиллаж Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 03/162 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шатахууны тооцоо бодолтыг шалгах

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 65,198.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 65,198.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч шийдвэрлэсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Тус байгууллагад аудитын явцад төлбөрийн акт бичигдээгүй болно.

4.3 Албан шаардлага

Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг харилцагч байгууллагын НӨАТ-ийн цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 64,758.5 мянган төгрөгийн гүйлгээ тусгай нууцлалын Аудитын код ТӨА-2022/61/-НА-СТА-ТШЗ

QR кодоор баталгаажуулаагүй ба анхан шатны баримтад хүлээн авсан, өгсөн хүний гарын үсэг, шалгасан нягтлан бодогчийн гарын үсэг бүрэн зурагдаагүй, тамга тэмдэг дарж албажуулаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой", " иж бүрэн байх " гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Төсвийн хөрөнгөөр 440.0 мянган төгрөгийн цаг бүртгэлийн төхөөрөмжийг худалдан авч батлагдаагүй төсвийн зардалд хөрөнгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн бол” албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Баянчандмань сумын ЗДТГ	2	65,198.5	-	-	-	-	2	65,198.5	-	-